

“АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО” –НЫ 2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:

УИХ “Жолоочийн даатгалын тухай” хуулийг 2011 оны 10-р сарын 06-нд батлан гаргаснаар СЗХорооАЖДХолбоо /цаашид холбоо гэх/ ТББ-ыг 2011.11.07-нд үүсгэн байгуулсан. Холбооны ажлын алба 2011.12.01-ний өдрөөс 3 орон тоотойгоор ажиллаж эхлэв.

Албан журмын даатгагчдын холбоо нь “ Жолоочийн даатгалын тухай” хуулийн хэрэгжилтийг хангах, эрх зүйн орчинг бүрдүүлэх, гишүүн даатгагчдын эрх ашгийг хамгаалах, уялдаа холбоог сайжруулах, тус хуулийг хэрэгжүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, олон нийтэд албан журмын даатгалын талаар мэдлэг олгох, мэдээллийг түгээх асуудлыг шинэ шатанд гаргах зорилтуудыг дэвшүүлэн, үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаа.

Ажлын алба нь Холбооны Удирдах зөвлөлөөс баталсан 2012 оны төлөвлөгөөний үндсэн чиглэл болох

- Албаны бүтэц бүрэлдэхүүн, төсөв санхүү, аж ахуйг бүрдүүлэх
- Хууль хэрэгжүүлэхтэй холбоотой заавар, журам, аргачлал боловсруулж мөрдүүлэх
- Сургалт сурталчилгаа явуулах
- Гадаад харилцаа тогтоох, бэхжүүлэх гэсэн 4 чиглэлээр нийт 220 багц ажил төлөвлөн 90 хувийн гүйцэтгэлтэй ажиллав.

Тайлант хугацаанд Холбооны Удирдах зөвлөл нь 23 хуралдаанаар 48 асуудал хэлэлцэн шийдвэрлэж ажлын албаны үйл ажиллагааг зохицуулж чиглүүлсэн бө энэ хугацаанд ажлын алба нь нийт 679 бичгийн эргэлттэй байснаас хүний нөөцтэй холбоотой 49, үйл ажиллагаатай холбоотой 17 тушаал гаргасан байна. 303 албан бичиг хүлээн авч, 377 албан бичиг явуулсан байна. Үүнээс 28 албан бичигт хариу өгөв.

ХОЁР. АЖЛЫН АЛБАНЫ ДОТООД АЖИЛ, ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН ТАЛААР:

Холбооны Удирдах зөвлөлийн 2012.01.11-ний өдрийн 12 дугаар тогтоолоор АЖДХолбооны ажлын албаны бүтэц орон тоог 4 хэлтэс 22 орон тоотойгоор

шинэчлэн тогтоосон ба уг тогтоолын дагуу захиргаа удирдлагын хэлтэс, даатгалын сангийн хэлтэс, мэдээллийн сангийн хэлтэс, шуурхай албаны хэлтэс ажиллаж байна.

УЗ-ийн 2012.01.11-ний өдрийн хуралдааны 14 тоот тогтоолоор холбооны ажлын албаны 2012 оны төсвийг хэлэлцэж 647.0 сая төгрөгөөр төсөв батлагдсан.

Төсвийн гүйцэтгэл 379.0 сая төгрөг боллоо. / дэлгэрэнгүйг хавсаргав/ Холбооны орлогын төлөвлөгөөг 2,179.0 сая төгрөгөөр батлуулж, гүйцэтгэл нь 480.1 сая төгрөг боллоо.

Орлогын төлөвлөгөө 1,699.6 сая төгрөгөөр тасалдсан. Орлогын төлөвлөгөө тасалдсан гол шалтгаан нь Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.2, 22.1.4-т заасан эх үүсвэрүүдийг жолоочийн даатгалын санд төвлөрүүлж чадаагүйтэй холбоотой юм.

2012.02.02-нд албаны нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, санхүүгийн тайлангийн маягт хөтлөх журмыг Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

2012 онд хуримтлуулах орлогын төлөвлөгөө биелэгдэх боломжгүй болсонтой холбогдуулж төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн танилцуулга бэлтгэж, УЗ-ийн хуралд хэлэлцүүлж, 2012 оны төсөвт тодотгол хийж зардлыг бууруулах арга хэмжээ авч ажилласан. Үүний үр дүнд төсөвт зардлыг батлагдсан төсвөөс 273200.9 мян.төг-өөр бууруулж 2013 оны 1 дүгээр сарын үндсэн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэрийг бий болгож чадсан байна,

Ажилтнуудад зайлшгүй шаардагдах тоног төхөөрөмж компьютер, ширээ, сандал, бичгийн хэрэгсэл, утас, интернет сургалтын тоног төхөөрөмжөөр хангав. Эд аж ахуйн тооллого хийж хүн нэг бүрээр карт хөтөлж, эд хөрөнгө тавилга тоног төхөөрөмжийг хариуцуулан бүртгэлжүүллээ.

Ажлын байрны судалгаа явуулж, Орон зай төвийн 8 давхарт нийт 3 өрөө бүхий ажлын байр түрээслэх гэрээ байгуулж холбогдох засвар үйлчилгээ, тохижилтыг хийлээ.

Холбооны албан ёсны www.amt.mn домайн хаяг, и-мэйл үйлчилгээг авч нийт ажилтан, албан хаагч бүрт байгууллагын и-мэйл хаягийг нээж, албан ажлын хэрэгцээндээ ашиглах боломжийг бүрдүүлсэн.

Ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдах компьютер, техник хэрэгсэлийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, дотоод сүлжээг зохион байгуулж

үүсгэсэн. Мөн интернэтийн сүлжээний болон тусгай сүлжээнүүдийн холболтыг үүсгэж холбогдох үйлчилгээг Мобинэт ХХК-аас авч байна.

Жолоочийн даатгалын тухай хууль, холбогдох журам заавар болон Холбооны үйл ажиллагаа, олон нийтэд хандсан мэдээллийг тавих зорилгоор Холбооны албан ёсны веб сайтыг боловсруулж ажиллагаанд оруулсан бөгөөд мэдээ, мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна.

Холбооны ажлын албаны үндсэн үйл ажиллагааг хангах, даатгалын сан, түүний шуурхай алба, мэдээллийн санг зохих ёсоор бүрдүүлж ажиллуулах явдал юу юунаас чухал байлаа.

Даатгалын сан бүрдүүлэх ажлын талаар:

2012 онд “Жолоочийн даатгалын тухай” хуулийн 22-р зүйлд заасан даатгалын сан бүрдүүлэх эх үүсвэрүүдээс 22.1.1-д заасан даатгагч бүрээс төвлөрөх хөрөнгө болох 440.000 /дөрвөн зуун дөчин сая / төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Бусад төвлөрүүлэх эх үүсвэр болох “Жолоочийн даатгалын тухай” хуулийн 22.1.2, 22.1.3, 22.1.4, 22.1.5-д заасан эх үүсвэрүүд бодит шалтгаануудын улмаас даатгалын санд төвлөрөх боломжгүй болсон. 22.1.2, 22.1.4-д заасан эх үүсвэр нь “2012 оны улсын төсвийн тухай хуульд “ тусгаж өгөөгүй мөн зохицуулах журам нь батлагдаагүй шалтгаанаар, 22.1.3-д заасан эх үүсвэр нь нөхөн төлбөрийг хуулийн дагуу олгох хугацаа болоогүйтэй холбоотой болно. Холбооны санхүүжилтийн гол эх үүсвэр болох авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын 10 хувь, жолоочийн даатгалын хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх захиргааны хариуцлагын торгуулийн 50 хувийг жолоочийн даатгалын санд төвлөрүүлэх журмын төсөлд Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, ЗТБХБЯ-ны даатгалын асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн саналыг авч нэгтгэн журмын төслийг боловсруулан бэлтгэж Сангийн яаманд хүргүүлсэн

Даатгалын сангаас нөхөн төлбөр олгох, буцаан нэхэмжлэх явцад баримталж ажиллах Нөхөн төлбөрийн журамд нэмэлт өөрчлөлт оруулах, нөхөн төлбөрийн заавар, холбогдох гэрээний загваруудын төсөл бүртгэлийн маягтуудыг боловсруулж Санхүүгийн зохицуулах хороогоор батлуулсан. Даатгалын сангийн хэлтсийн үйл ажиллагааг бүрэн програмчлах ажлын хүрээнд програмын шаардлагыг бичиж энэ ажил дээр мэдээллийн сантай хамтран ажиллаж байна.

“Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам”-ын 3.1-д заасны дагуу арилжааны банк сонгох “Сонгон шалгаруулалтын зааврын төслийг боловсруулж Удирдах Зөвлөлд танилцуулан уг зааврын дагуу 6 банкинд сонгон шалгаруулалтын урилга хүргүүлэн хариу аваад байна. Тус журамд заасны дагуу даатгалын сангийн үйл ажиллагаанд аудитын хяналт шалгалт хийх Аудитын компанийг сонгох зааврын төсөл боловсруулан Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулж тус тус бэлэн болгов.

Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах” журмын 4.4-т өөрчлөлт оруулах тухай танилцуулга, тооцоо гаргаж, Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Хорооны хуралд оруулах шийдвэр гаргуулсан.

Сангийн яамны Төсвийн бодлогын газар, Төрийн сангийн газарт орон нутгийн төсвөөс АТӨЯХАТ-ын 10 хувь, торгуулийн 50 хувийг татан төвлөрүүлэхэд үүсээд байгаа зөрчилд хариу авах тухай албан тоот, Жолоочийн даатгалын тухай хуульд заасан дээрх хөрөнгийг шилжүүлэх журмын төслийг хүргүүлж, холбогдох газруудтай хамтран ажиллаж байна.

Аймаг, нийслэлийн Засаг даргынтамгын газрын санхүү, төрийн сангийн хэлтсүүдээс тус тусын төсөвт суулгасан АТӨЯХАТ-ын 10 хувийн мэдээ авч нэгтгэн УЗ-д танилцуулж, дээрхи хөрөнгийг санд шилжүүлэх хуваарийг батлуулах албан тоот хүргүүлсэн. Мөн бүх аймаг нийслэлийн засаг дарга нарт Жолоочийн даатгалын хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хамтран ажиллах, санд төвлөрүүлэх хөрөнгийг цаг хугацаанд шилжүүлэхэд дэмжлэг үзүүлж байх талаар албан тоот хүргүүлээд байна.

Даатгалын сангийн шуурхай албыг зохион байгуулах талаар:

Тайлант хугацаанд Шуурхай албаны бүтэц, бүрэлдэхүүн, орон тоо, хүн хүч, техник хэрэгсэл, хөрөнгө оруулалт, цалин хөлс, урсгал зардлын талаар төсөв боловсруулан Удирдах зөвлөлд, Санхүүгийн зохицуулах хороонд танилцуулж шаардлагатай орон тоон дээр хүний нөөц бүрдүүлэх, тэднийг сургаж дадлагжуулах, хувийн бэлтгэл хангуулах зэрэг ажил хийгдэв.

“Шуурхай алба нь жолоочоос шалтгаалан гарсан зам тээврийн ослын талаарх мэдээллийг даатгуулагч, даатгагч, жолооч, хохирогч, иргэдээс хүлээн авч, даатгалын

тохиолдлын улмаас хохирогчид олгох нөхөн төлбөрийг шуурхай, үнэн зөв тодорхойлох боломжийг даатгуулагч, даатгагч, жолооч, хохирогчид бүрдүүлж ажиллана” гэсэн хуулийн **25.2** дахь заалтыг хэрэгжүүлэхийн тулд Шуурхай албыг нийслэл болон орон нутгийн хэмжээнд ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг 4 байгууллагын жишээнд тулгуурлан 4 хувилбараар боловсруулж холбооны удирдлага, Удирдах зөвлөлд танилцуулан өгөгдсөн зөвөлгөө, удирдамжийн дагуу дахин боловсруулж шийдвэр гаргуулан ажиллалаа.

“Жолоочийн даатгалын сангийн шуурхай албаны ажиллах журам”-ын **зургаа, долоо** дугаар зүйлүүдийг хэрэгжүүлэхийн тулд “Шуурхай албаны автомашины өнгө, таних тэмдэг, дуудлагын ажилтны өмсгөл/хантааз/-ийн загвар” боловсруулж Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулан гишүүн даатгалын компаниудад мөрдүүлж байна

2013 онд нийслэлд 4 ээлж буюу 24/72 цагаар ажиллах, орон нутагт 8 аймагт шуурхай албыг байгуулах бэлтгэл хангаад байна

“Даатгалын тохиолдлын дуудлага хүлээн авах, тохиолдлын газрын үзлэг хийх, баримтжуулах, шилжүүлэх үйл ажиллагаанд мөрдөх заавар”-ын төсөл боловсруулж бэлэн болгоод байна

“МИГ даатгал”, “Мандал даатгал”, “Мөнх даатгал” компаниудтай хамтран ажиллах гэрээ байгуулан тэдний даатгуулагч нарын **187** даатгалын тохиолдлын дуудлагыг шөнийн цагаар хүлээн авч, **173** даатгалын тохиолдлын үзлэг хийж холбогдох **1233** хуудас материалыг бүрдүүлэн заасан хугацаанд хүргүүлж ажиллав. Үүнд:

МИГ даатгал ХХК-д 294 хуудас бүхий 42 материал,

Мандал даатгал ХХК-д 327 хуудас бүхий 45 материал,

Мөнх даатгал ХХК-д 612 хуудас бүхий 86 материал

тус тус бүрдүүлэн хүргүүлснээс гэрээт 3 компаний болон тэдгээрийн даатгуулагч, хохирогч нарын зүгээс ямар нэг гомдол гараагүй байна.

Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, сүлжээ бий болгох, ашиглах талаар:

Жолоочийн даатгалын тухай хуулийн 24.1-д заасан мэдээллийн сангийн үйл ажиллагаа, холбогдох харилцааг зохицуулсан “Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн журам”-ыг боловсруулж Санхүүгийн зохицуулах хороогоор батлуулав.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 24.6-д заасны дагуу жолоочийн даатгалын мэдээллийн сангаас лавлагаа, мэдээлэл олгох үйл ажиллагаа, холбогдох харилцааг зохицуулсан “Жолоочийн даатгалын мэдээллийн сангаас лавлагаа, мэдээлэл олгох тухай журам”-ын төслийг боловсруулан санал авахаар Удирдах зөвлөлд хүргүүлээд байна.

Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ашиглагдах програм хангамжийг боловсруулж нэвтрүүлэх талаар:

Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн мэдээллийн нэгдсэн автоматжсан системийг боловсруулахад шаардагдах програм, техник хангамжийн шаардлагыг нарийвчлан тодорхойлсон “Бодлогын даалгавар”-ыг боловсруулсан.

Бодлогын даалгаврын дагуу “Мэдээллийн нэгдсэн автоматжсан системийг боловсруулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер”-ийн баримт баримт бичгийг боловсруулан гаргасан.

Мэдээллийн нэгдсэн автоматжсан системийн тендерийн үнэлгээний хорооны хуралдааны холбогдох баримт бичгүүдийг боловсруулан гаргаж, тендерийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг зохион байгуулав.

Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ашиглагдах өгөгдлийн сан, бүртгэлийн үндсэн програм хангамж, гишүүн даатгалын компаниудаас жолоочийн даатгалын мэдээ хүлээн авах, тэдгээр цахим хэлбэрээр лавлагаа, мэдээлэл олгох үүрэг бүхий програм хангамжуудыг боловсруулсан.

Мэдээллийн сангийн хэлтсээс жолоочийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн програм хангамжийн системийн шаардлага, дизайныг нарийвчлан гаргах, тестлэх, нэвтрүүлэх, алдаа дутагдалыг олж илрүүлэн, засварлуулах зэрэг ажлуудыг хариуцан гүйцэтгэж гэрээт програмистуудтай нягт хамтран ажиллаж байна.

Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн програм хангамж суурьлагдан ажиллах серверүүдийг Санхүүгийн зохицуулах хорооноос түрээслэн авч холбогдох тохиргоог хийж ажиллагаанд оруулсан. Мөн Санхүүгийн зохицуулах хороон дээр байрлах серверүүдтэй Холбооны дотоод сүлжээг нууцлалт хамгаалалт бүхий тусгай сүлжээгээр холбосон.

Жолоочийн даатгалын мэдээллийг гишүүн даатгалын компаниудаас хүлээн авч мэдээллийн сан бүрдүүлэх талаар:

Гишүүн даатгалын компаниудаас жолоочийн даатгалын гэрээ, нөхөн төлбөрийн мэдээллийг хүлээн авахад зорилгоор жолоочийн даатгалын мэдээ хүлээн авах маягт, стандарт файлыг /XLS/ боловсруулан гаргасан.

Гишүүн даатгалын компаниудаас жолоочийн даатгалын мэдээллийг сар бүр хүлээн авч нэгтгэн тайлан, судалгааг тухай бүр гарган ажилласан.

Гишүүн даатгалын компаниудаас ирүүлж буй мэдээлэл нь алдаа, дутагдал ихтэй нэгдсэн нэг стандарттай биш байсан тул жолоочийн даатгалын мэдээллийн санг бүрэн гүйцэд мэдээлэлтэй байлгахын тулд нийт мэдээллийг нэгтгэн боловсруулж нэгдсэн стандартад оруулах ажлыг хийлээ

Холбоо 2012 онд гишүүн даатгалын 15 компаниас нийт 11,787,779,442 төгрөгийн хураамж бүхий 318,088 даатгалын гэрээний мэдээлэл, 2,557,860,839 төгрөгийн нөхөн төлбөр олгогдсон дүн бүхий 5,571 даатгалын тохиолдолдын мэдээлэл хүлээн аваад байна. Одоогийн байдлаар мэдээллийн сангийн 1-р шатны шалгалтын шаардлага хангасан 142,497 даатгалын гэрээ, 425 даатгалын тохиолдолын мэдээлэл мэдээллийн санд орсон байна. Орвол зохих мэдээллийн 50 орчим хувь нь ороод байна гэж ойлгож болно.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 26.3, 26.4 дэх заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Зам тээврийн яам, Замын цагдаагийн газруудтай мэдээллийн сангийн төвшинд харилцан холбогдож мэдээлэл солилцох зорилгоор хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

ГУРАВ. ГИШҮҮН ДААТГАГЧДЫН УЯЛДАА ХОЛБООГ ХАНГАХ, ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР:

Жолоочийн даатгалын тухай хууль хэрэгжүүлэхэд жолооч, тээврийн хэрэгслийн өмчлөгч, даатгагчдын гурвалжиныг идэвхжүүлж, уялдаа холбоог хангах, үүрэг АЖДХ-нд ноогдож байгаа юм. Энэ уялдаа холбоог хангахын тулд эрх зүйн орчин бий болгож, тус бүрийн эрх үүргийг ойлгомжтойгоор тодорхойлж хэрэгжилтэнд АЖДХ-ны ажлын алба хяналт тавьж ажиллах зорилготой ажиллаж байна.

Холбооны дүрмийн дагуу СЗХорооноос албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгалын 15 компанийг гишүүнээр бүртгэн гишүүний

батламжийг гардуулсан. Гишүүн даатгалын компаниудын уялдаа холбоог сайжруулах, жолоочийн даатгалын үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад тулгарч буй хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор нийт 4 удаагийн нэгдсэн ажил хэргийн уулзалт зохион байгуулав.

Энэ уулзалтуудаар АЖДХолбооноос хийж буй ажлын тайлан, даатгалын компаниудаас авто тээвэр, оношлогооны газрууд дээр даатгал хийх явцад үүсгэж байгаа хууль зөрчсөн үйлдлүүдийн талаар хэлэлцэж тухай бүр зохих шийдвэрүүдийг гаргаж байв. Үүний үр дүнд дээрх газруудад даатгал хийж буй компаниуд нь 3-аас дээш тооны төлөөлөгч ажиллуулахгүй байх, өөрсдийн байр талбайд даатгал хийх , даатгал хийж буй төлөөлөгч нарт тухайн компанийн таних тэмдэг бүхий хувцас форм хэрэглэх, бүх шуурхай албаны машинд анивчдаг гэрлийн зөвшөөрөл авч өгөх, автомашинуудыг нэг өнгө будагтай байх стандартыг мөрдөх зэрэг асуудлууд тодорхой хэмжээгээр шийдвэрлэгдэв.

“Жолоочийн даатгалын баталгааны загварыг хэрэглэх журам”-ын дагуу даатгалын баталгааны бүрдэл болох бар код, цахим мэдээлэл уншигч чипийг хэрэглэхэд үүсэх хүндрэлтэй асуудлуудыг судалж Холбооны Удирдах зөвлөл болон даатгалын компаниудад танилцуулан 2 удаагийн хурлаар хэлэцүүлсний үндсэн дээр 2012 онд наалт хэлбэрээр даатгалын баталгааг хэвлүүлэхээр шийдвэрлэн хэрэгжүүлж байна.

“Даатгалын баталгааг хэрэглэх журам” –д заасны дагуу Даатгалын баталгаа хэвлэх компанийг сонгох тендер зарласан бөгөөд тендерт “Адмон” ХХК шалгарч, гишүүн даатгагчдаас 2012 оны хэрэгцээт даатгалын баталгааны захиалгыг авч нэгтгэн 400,000 ширхэг баталгаа, 2013 оны 1-р улирлын нийт захиалга болох 171,500 ширхэг батлагааг хэвлүүлэн компаниудад захиалгын дагуу тараан өгөөд байна.

Даатгалын баталгаатай холбоотойгоор даатгалын хэлтсээс “Даатгалын баталгааг хэрэглэх түр заавар”, захиалгын хуудас, зөрчилтэй баталгаа хүлээлцэх акт, бүртгэлийн хуудас, баталгааны зарцуулалт, үлдэгдлийн тайлан өгөх маягт, хэвлэлийн компанитай хүлээлцэх акт зэргийг боловсруулан Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулан мөрдөж байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан жолоочийн хариуцлагын даатгалын мэдүүлгийн маягт болон гэрээг англи хэл дээр орчуулсан. “Жолоочийн даатгалын тухай” хууль хэрэгжүүлэхтэй холбогдон гарч байгаа тодорхойгүй асуултуудыг даатгалын

компаниудаас авч нэгтгэн СЗХорооноос зөвлөмж авсны үндсэн дээр хариултыг бэлтгэн даатгалын компаниудад албан тоотоор хүргүүлсэн. Ингэснээр хуулийн заалтыг нэг ойлголтоор хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэв.

“Жолоочийн даатгалын тухай” хуулийн 24-р зүйлд заасны дагуу үүсгэх Мэдээллийн санд ирүүлж буй мэдээллийн алдаа, зөрчлийг багасгах, чанартай мэдээлэл хүлээн авах зорилгоор гишүүн даатгалын компаниудын мэдээллийн сангийн бүртгэлийн ажилчид, даатгалын төлөөлөгчдөд жолоочийн даатгалын мэдээ боловсруулах талаар сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 90 хүнийг хамруулаад байна.

Жолоочийн даатгалын мэдээллийг алдаагүй, бүрэн хүлээн авахтай холбогдуулж гишүүн даатгалын компанийн жолоочийн даатгалын үйл ажиллагаанд ашиглагдах програм хангамжид тавигдах шаардлагыг боловсруулан гаргаж Удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж хүргүүлэв.

Удирдах зөвлөлийн 2012 оны 9-р сарын 4-ны өдрийн 32 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор гишүүн даатгалын компаниудын програм хангамжийг боловсруулж буй байгууллага, хувь хүн, даатгалын компанийн бүртгэл, програм хангамж хариуцсан ажилтнуудад заавар, зөвлөгөө өгч, уулзалт ярилцлага зохион байгуулав.

2013 оны 1-р сарын 1-ны өдрөөс эхлэн жолоочийн даатгалын мэдээллийн сан албан ёсоор ажиллаж эхлэхэд бэлэн болсон . Одоогийн байдлаар гишүүн даатгалын компаниуд мэдээллийн сантай холбогдон ажиллахад ашиглагдах програм хангамжийн нэвтрүүлэлтийн ажил хийгдэж байна.

Замын цагдаагийн албанаас даатгагч нарт болон даатгалын санд олгох даатгалын тохиолдлын тухай тодорхойлолтын загвар боловсруулж нийт аймаг, нийслэл, дүүргийн ЗЦ-ийн албадад хүргэж мөрдүүлэн ажиллаж байна.

Тээврийн прокурорын газартай “Жолоочийн даатгалын тухай” хуулийн 28 дугаар зүйлд заасан “Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага” -ын заалтуудыг хэрэгжүүлэхэд тодорхой чиглэл гаргуулахаар тохиролцоонд хүрч хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй гэсэн дүгнэлт гаргууллаа. Ингэснээр 2012.10.01-с эхлэн хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг шууд хэрэгжүүлэх боломжийг бүрдүүллээ. Гэхдээ энэ ажил хараахан хэрэгжиж эхлээгүй байна

ДӨРӨВ.СУРГАЛТ СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААР:

Сурталчилгааны ажлын талаар:

2012.01.01-ээс “Жолоочийн даатгалын тухай “ хуулийг хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан хуулийн талаар олон нийтэд сурталчлах, даатгалд идэвхитэй хамруулах ,зөв, нэгдсэн ойлголт төлөвшүүлэх зорилгоор голлон анхаарч, дараах ажлуудыг хийв.

2012.02.02-нд МҮОНР телевиз дээр Албан журмын даатгагчдын холбоо, Санхүүгийн зохицуулах хороо, ХЗДХЯ, ЗЦГ, ЗТБХБЯ, Авто тээврийн газрын төлөөлөлтэй “Жолоочийн даатгалын тухай “ хууль сурталчлах хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Мөн энэ хэлэлцүүлгийн бичлэгийг автын үзлэг оношлогоо явагдахын өмнө хөдөө орон нутгийн төрийн сангийн хэлтсийнхэнээр дамжуулан орон нутгийн телевизээр нэвтрүүлүүлсэн нь “Жолоочийн даатгалын тухай” хууль хэрэгжиж эхлээд байгаа тухай олон нийтэд мэдээлсэн цаг үеэ олсон сурталчилгаа болсон.

Сурталчилгааны ажлын хүрээнд мэдээллийн самбар 120 ш, гарын авлага 120.000 ширхэгийг хэвлүүлэн АТГазар, Оношлогооны 4 төв, ЗЦГ, нийслэлийн дүүргүүдийн замын цагдаагийн тасаг, 11 аймгийн төвүүдэд байрлуулж, гишүүн компаниуд, даатгуулагч, иргэдэд тараав. Сурталчилгааны материалд жолоочийн даатгалын талаарх ерөнхий ойлголт , даатгал хийх эрх бүхий компаниудын мэдээлэл байрласнаар даатгуулагч байгууллага ард иргэдэд жолоочийн даатгалын тухай мэдээллийг нэг дороос авах боломжийг бүрдүүллээ.

Автын үзлэг оношлогоо явагдах явагдах үеэр Инээмсэглэл 99,3, Шинэ долгион 107,5, Улаанбаатар 102,5, Нандин 105,5 гэсэн 4 FM радиогоор 1 сарын хугацаатай, 1440 удаа хуулийн сурталчилгааны шторк цацуулав. Авторадио 96,3 FM радиогоор 1 жилийн хугацаатай сурталчилгааны шторк мэдээлэл цацуулах гэрээ хийж, эфирийн цагуудад тухай бүр хяналт тавин ажиллаж байна

Авторадио 93,6 радиогийн “Жолоочийн цаг” нэвтрүүлгээр ярилцлагад орж, жолооч нарын асуулт хариултанд хариулахаар тохиролцон 10 удаагийн нэвтрүүлэгт орсон.

Жолоочийн даатгалын тухай хуулийг сурталчлах зорилгоор МҮОНРТ-тэй хамтран теле болон радио хичээл бэлтгэн МҮОНРТ-ээр 4 удаа, Монголын радиогоор 20 удаа, NTV телевизээр 4 удаа, MN 25 телевизийн өргөн нэвтрүүлгийн 1,2-р сувгаар тус бүрээр 2 удаа, Оллоо телевизээр 2 удаа нийт 14 удаа цацаж нэвтрүүллээ.

Монголын радиогийн залуучуудад зориулсан ”Боломж”, “Авто радио сонин” нэвтрүүлгийн цагуудаар хууль гарах болсон шалтгаан, жолоочийн даатгалд хамрагдсаны

ач холбогдол, хэрхэн яаж даатгуулах тухай, албан журмын даатгагчдын холбооны үйл ажиллагааг танилцуулах зэрэг сэдвүүдээр ярилцлага зохион байгуулав.

Эдгээр сурталчилгааны үр дүнд “Жолоочийн даатгалын тухай” хуулийн 5-р зүйлд заасан этгээдүүд заавал даатгуулах ёстойг ойлгуулсан үр дүнтэй ажил болсон.

2012 оны 09-р сарыг Жолоочийн даатгалын хуулийн сурталчилгааг эрчимжүүлэх сар болгож Даатгалын компаниудын маркетингийн менежерүүдийг цуглуулан ажил хэргийн уулзалт хийв. Уулзалт ярилцлагад 12 даатгалын компани оролцож санал бодлоо солилцсон. Үүний дагуу даатгалын компаниудын гаргасан төлөвлөгөөг нэгтгэж УЗ, СЗХороонд танилцуулан цаашид ажиллах чиглэл авч хуулийн сурталчилгаа, хариуцлагын механизмыг иргэдэд ойлгуулах мэдээлэх ажлыг СЗХ, Албан журмын даатгагчдын холбоо хариуцан хийж, нийт авто тээврийн эзэмшигч, жолооч нарыг 2012.10.01-нээс өмнө амжиж даатгуулахыг уриалах сурталчилгааны ажлыг даатгалын компаниуд хуваарийн дагуу хийхээр тогтож ажиллав.

Сурталчилгааны ажлыг санхүүжүүлэх зорилгоор төсөл бичиж олон улсын байгууллагуудад хандсаны үр дүнд USAID-ийн төслөөр иргэдэд тараах гарын авлага, 9 ширхэг сурталчилгааны самбарын эх бэлтгэн хэвлүүлэх, байрлуулах, ТВ, радиогийн шторкийн эх бэлтгэж цацуулах ажлыг хийлээ.

Сурталчилгааны сарын ажлын хүрээнд Сүхбаатарын төв талбайд зуучлалын Изи инвестмент ХХК-тай хамтран 2012.09.22-23-ны өдрүүдэд “Даатгалын өдөрлөг” зохион байгуулж, Тэнгэр, Ард, Номин, Монре, Монгол, Бодь, Мөнх, Миг, Мандал генерал даатгал ХХК, нийт 9 даатгалын компани оролцож, 3613 даатгалын баталгаа олгож, 3764 даатгалын гэрээ шинээр хийсэн байна.

Даатгалын өдөрлөгт Албан журмын даатгагчдын холбооны нийт ажилтнууд оролцож, иргэдэд хуулийн сурталчилгаа тайлбар, зөвөлгөө өгч, Сүхбаатарын талбайн ойр орчмын газар, Нарантуул худалдааны төв, Өгөөмөр зах, Да хүрээ зах, техникийн зах, Баянзүрхийн товчоо орчимд байгаа тээврийн хэрэгслүүдэд сурталчилгааны материал санамж тарааж зөвөлгөө өгч үзэлээр зар явууллаа. Өдөрлөгийн 2 өдөрт нийтдээ 7000 орчим тараах материал, 1000 гаруй анхааруулга тарааж, Жолоочийн даатгалын хуулиар 500 орчим хүнд мэдээлэл зөвөлгөө өгч, асуултанд хариулсан байна.

Даатгалын өдөрлөг, сурталчилгааны сарын ажлын талаар Эко ТВ, SBN, Шууд, PPchannel, Эх орон ТВ, За ТВ, Шинэ дэлхий Тв, ТВ 9, ТВ 8, ТВ 5, нийт 10 телевиз,

Үндэсний шуудан, Нийслэлийн таймс сонин, МҮОНРадио, ФМ радиогоор мэдээлж, ярилцлага мэдээлэл цацлаа.

Даатгалд хамруулах нэг сарын аяныг зохион байгуулсанаар “Жолоочийн даатгалын тухай” хуулийн 29.2-д заасан хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага тооцох хугацаа 2012.10.01-с эхлэх гэж байгааг нийт жолооч нарт мэдээлсэн бөгөөд хугацаанаас өмнө амжиж даатгуулахыг уриалсан ажил болсон. Энэ сарын ажлын үр дүнд даатгалын хамрагдалт 46 хувиар нэмэгдсэн.

Сургалтын ажлын талаар:

“Сургалт 2012” ажлын хүрээнд шинээр УЗ-с баталсан төлөвлөгөөний дагуу Жолоочийн даатгалын хуулийг олон нийтэд сурталчлах, оролцогч байгууллагуудын ажилтнуудыг чадавхижуулах, нэгдсэн ойлголттой болгох, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах зорилгоор Авто тээврийн газар, ТХОХЗ-ын алба, Нийслэлийн тээврийн газар, Даатгалын болон үнэлгээний компанийн ажилтнууд, ЗЦГазрын байцаагч, зохицуулагчдыг оролцуулан Улаанбаатар хотод 7 удаа, Баян-Өлгий, Ховд, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Хэнтий, Дархан-Уул, Орхон, Архангай, Өвөрхангай зэрэг нийт 10 аймаг, нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт нийт 15 удаа, бүгд 22 удаагийн сургалт зохион байгуулж, 767 хүнийг сургалтанд хамрууллаа.

Энэ сургалтын гол зорилго, үр дүн нь “Жолоочийн даатгалын тухай” хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан хуулийн агуулгыг танилцуулж, мөн хуулийн 28.1.5-д зааснаар даатгуулаагүй тээврийн хэрэгслийг үзлэг, оношлогоонд оруулахгүй байх, замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх мөн хуулийн эдгээр заалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаарх ойлголт мэдээлэлийг хээгжүүлэгч байгууллагуудын албан хаагчдад өгч , хуулийн хэрэгжилтийг хангах гол нөхцөлийг бүрдүүлсэн ажил болсон.

Сургалтанд оролцогчидтой эргэж холбогдон мэдээлэл авахад сургалтаар олж авсан мэдлэг, мэдээллээ орон нутагтаа хүргэх, хэрэгжүүлэх, дахин сургалт зохион байгуулахад ашиглаж байгаа санаачлагууд гарч байгаа нь сайшаалтай байлаа.

Жолоочийн даатгалын тухай хуулийг сурталчлах зорилгоор бэлтгэсэн Теле болон радио хичээлийг 21 аймгийн санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлэн орон нутгийн телевиз, радиогоор цацуулсан. Мөн эдгээр сурталчилгааны материалуудыг орон нутгийн

даатгалын компаниудад сурталчилгаандаа ашиглах талаар зөвлөмж өглөө. Тайлант хугацаанд орон нутгийн телевизийн эфирээр давхардсан тоогоор 320 удаа нэвтрүүлсэн нь орон нутгийн автотээврийн хэрэгсэлийн эзэмшигч, жолооч нарт заавал даатгуулах ажлын ач холбогдолыг ойлгуулж, даатгалд хамрагдалтыг орон нутгийн хэмжээнд нэмэгдүүлсэн.

Ажлын албаны ажилтнуудын хувьд даатгалын чиглэлээр ажиллаж байсан туршлагатай ажилтан цөөн байгааг харгалзан даатгалтай холбогдох мэдлэгийг гүнзгийрүүлэх, даатгалаар мэргэшүүлэх зорилгоор 10 удаагийн системчилсэн сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж, даатгалын чиглэлээр мэргэшсэн багш нарыг урин сургалт явууллаа.

Ажилтнуудад “Жолоочийн даатгалын тухай” хууль, хууль хэрэгжүүлэхэд тулгарч буй хоёрдмол утгатай заалтыг мэргэжлийн түвшинд тайлбарлах, даатгалын талаар сургалт явуулах сургагч багшийг чадавхижуулах, даатгалын талаарх ерөнхий ойлголт, байгууллагын төлөвшил, соёл зэрэг сэдвүүдээр сургалт хийв. Энэ сургалтанд хамрагдсан ажилтнуудын даатгалын зах зээлийн талаарх мэдлэгийн түвшин эрс дээшилж ажлын бүтээмж нэмэгдсэн.

Гадаад харилцааны талаар:

БНСУ-ын Сөүл хотод дэд захирал Б.Цэвээнпүрэв, даатгалын сангийн хэлтсийн мэргэжилтэн С.Хишигзаяа, Мэдээллийн сангийн хэлтсийн дарга Н.Ганбат нар тус улсын даатгалын хөгжлийн институт, жолоочийн даатгал, мэдээллийн сангийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах, зорилгоортомиллоор ажиллалаа. Энэ томилолтын гол ач холбогдол нь Албан журмын даатгалын тогтолцоог эхлүүлж байгаа энэ үед жолоочийн албан журмын даатгалыг 20 жил хөгжүүлсэн солонгос улсын туршлагатай танилцан судлаж өөрсдийн үйл ажиллагаанд тусгах боломжийг бүрдүүлсэнээрээ чухал ач холбогдолтой ажил боллоо. /Ажлын тайланг хавсаргав/

ТАВ. ДҮГНЭЛТ

АЖДХ нь 2012 онд хуульд заасан хэлтэс албадыг үүсгэн байгуулах, боловсон хүчнийг бүрдүүлэх, даатаглын сан, мэдээллийн сан, даатгалын сангийн шуурхай албыг ажиллуулахад зайлшгүй шаардлагатай холбогдох эрх зүйн актуудыг боловсруулах,

гишүүн даатгагчидын уялдаа холбоог хангах, эрх ашгийг хамгаалах зэргээр хууль хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн ажлуудын хийж гүйцэтгэсэн болно.

Мөн тус Холбоо нь “Жолоочийн даатгалын тухай хууль”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сургалт сурталчилгааны бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд нь хяналт тавихад гол анхаарлаа чиглүүлж ажилласны үр дүнд нийслэл, орон нутагт хууль хэрэгжүүлэгч төрийн болон төрийн бус байгууллагууд, иргэдийн дунд жолоочийн даатгалын талаарх мэдлэг мэдээллийн түвшин дээшилж, шаардлагатай заавар зөвлөмжийг АЖДХ-с авах, харилцан мэдээлэл солилцох зэргээр байнгын хамтын ажиллагааг хэвшүүлж байна.

Жолоочийн даатгалын тухай хуулийг нийтэд ойлгуулах, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор Холбоо сургалт сурталчилгааг нэгтгэн эрчимтэй явуулсаны үр дүнд нийт тээврийн хэрэгсэлийн 80 гаруй хувь нь даатгалд бүрэн хамрагдсан үр дүнтэй ажилласан байна.

Жолоочийн даатгалын тухай хууль батлагдсантай холбогдуулж холбогдох хууль, тогтоомж мөн түүнийг хэрэгжүүлэхээр баталж мөрдүүлсэн эрх зүйн баримт бичгүүдийг судалж, заалтуудын уялдаа холбоог хянан мониторинг хийх шаардлагатай байна.

Холбооны гишүүдэд албан журмын даатгал эрхлэх хүрээнд зөвлөлгөө өгөх, мэдээлэл өгөх, ашиг сонирхолыг нь хамгаалах чиглэлд хэрхэн яаж ажиллах ярилцлага зохион байгуулах, олон улсын хэмжээнд туршлага судлаж ажиллана.

Холбооны Удирдах зөвлөлөөс баталсан 2012 оны төсвийн хүрээнд үйл ажиллагааны чиглэлийг баримтлан ажлын албаны анхаарлыг төвлөрүүлж ажиллах болно. Даатгалын санд төвлөрүүлэх зохих орлогыг бүрэн төвлөрүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, шуурхай албыг зохих түвшинд ажиллуулахад 2013 оны гол ажил чиглэгдэнэ.